| 210201      | Тэтгэврийн даатгал   | 15,754,200.00 | 15754200.00   | 17832100.00   | 17360888.11         |
| 210202      | Тэтгэмжийн даатгал   | 1,824,000.00  | 1824000.00    | 2097800.00    | 2042398.59          |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал  | 1,459,300.00  | 1459300.00    | 1678300.00    | 1633518.87          |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал   | 364,800.00    | 444100.00     | 419600.00     | 408879.72           |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал  | 3,648,000.00  | 3568700.00    | 4195800.00    | 4084897.18          |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                     | 21055800.00   | 20284650.00   | 20894700.00   | 19556251.00         |
| 210301      | Гэрэл, цахилгаан   | 6,000,000.00  | 5528400.00    | 7894700.00    | 6585751.00          |
| 210302      | Түлш, халаалт  | 15,055,800.00 | 14756250.00   | 13000000.00   | 12970500.00         |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | 18647700.00   | 18121301.00   | 16398700.00   | 15403785.00         |
| 210401      | Бичиг хэрэг  | 2,028,300.00  | 1758560.00    | 1779300.00    | 1506460.00          |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 14,794,500.00 | 14794500.00   | 12544500.00   | 12111325.00         |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 1,824,900.00  | 1,568,241.00  | 2,074,900.00  | 1,786,000.00        |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>  | 8,071,000.00  | 5,587,000.00  | 2,554,700.00  | 1,812,000.00        |
| 210702      | Дотоод албан томилолт  | 8,071,000.00  | 5,587,000.00  | 2,554,700.00  | 1,812,000.00        |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | 4,646,300.00  | 4,313,193.00  | 2,320,600.00  | 1,636,605.00        |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,749,700.00  | 3,510,231.00  | 1,500,000.00  | 1,000,000.00        |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 120,000.00    | 120,000.00    | 324,000.00    | 324,000.00          |
| 210803      | Даатгалын үйлчилгээ  | 160,000.00    | 160,000.00    | 300,000.00    | 125,605.00          |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар   | 350,600.00    | 256,962.00    | 121,000.00    | 121,000.00          |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношлогоо  | 66,000.00     | 66,000.00     | 66,000.00     | 66,000.00           |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | 15,813,474.00 | 15,538,400.00 | 20,400,000.00 | 18,158,500.00       |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 11,313,474.00 | 11,250,400.00 | 19,500,000.00 | 17,723,500.00       |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 4,500,000.00  | 4,288,000.00  | 900,000.00    | 435,000.00          |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | 6,125,900.00  | 5,920,900.00  | 1,000,000.00  | 745,000.00          |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | 6,125,900.00  | 5,920,900.00  | 1,000,000.00  | 745,000.00          |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 700,000.00    | 495,000.00    | 1,000,000.00  | 745,000.00          |
| <b>2135</b> | <b>төсвийн захирагчаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>             | -             | -             | -             | <b>2,772,454.12</b> |
| <b>2135</b> | <b>0.0</b>   | -             | -             | -             | <b>2,772,454.12</b> |
| 213503      | төвлөрүүлэх шилжүүлэг  |               |               |               | 2,772,454.12        |

|               |  |              |              |              |              |
|---------------|--|--------------|--------------|--------------|--------------|
|               | <b>ЗАРДЛЫГ<br/>САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ<br/>ҮҮСВЭР</b>        | -            | 1,326,674.00 | 400,000.00   | 694,500.00   |
| <b>120004</b> | <b>ТӨСӨВТ<br/>БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ<br/>АЖИЛЛАГААНААС</b> | -            | 1,326,674.00 | 400,000.00   | 694,500.00   |
| 1200041       | Үндсэн үйл<br>ажиллагааны орлогоос<br>санхүүжих      | -            | 749,000.00   | 400,000.00   | 694,500.00   |
| <b>61</b>     | <b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>                              | -            | -            | 1.00         | 1.00         |
| 610001        | Төсвийн<br>байгууллага                               | -            | -            | 1.00         | 1.00         |
| <b>62</b>     | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>                              | -            | -            | 24.00        | 24.00        |
| 620001        | Удирдах ажилтан                                      | -            | -            | 5.00         | 5.00         |
| 620002        | Гүйцэтгэх ажилтан                                    | -            | -            | 10.00        | 10.00        |
| 620003        | Үйлчлэх ажилтан                                      | -            | -            | 9.00         | 9.00         |
| <b>65</b>     | <b>ОРОН ТООНЫ<br/>МЭДЭЭЛЭЛ</b>                       | <b>24.00</b> | <b>24.00</b> | <b>24.00</b> | <b>10.00</b> |
| 650001        | Төрийн захиргааны албан<br>хаагч (ТЗ)                | 6.00         | 6.00         | 6.00         | 6.00         |
| 650011        | Улс төрийн албан хаагч<br>(УТ)                       | 4.00         | 4.00         | 4.00         | 4.00         |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны<br>код | Үзүүлэлт   | Өмнөх он             | Гүйцэтгэл             |
|---------------|--|----------------------|-----------------------|
|               | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>  |                      |                       |
| <b>I</b>      | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>   | <b>15,541,325.00</b> | <b>114,737,153.00</b> |
| <b>21</b>     | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>15,541,325.00</b> | <b>114,737,153.00</b> |
| <b>210</b>    | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | 15,541,325.00        | 114,737,153.00        |
| <b>2108</b>   | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,<br/>хураамж</b>  | -                    | 2,068,513.00          |
| 210801        | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил<br>үйлчилгээний төлбөр хураамж  | -                    | 2,068,513.00          |
| <b>2109</b>   | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>   | 15,541,325.00        | 112,668,640.00        |
| 210901        | Бараа үйлчилгээний бусад зардал  | 15,541,325.00        | 112,668,640.00        |
| <b>2133</b>   | <b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>   | -                    | <b>270.00</b>         |
| 213503        | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх<br>шилжүүлэг  | -                    | 270.00                |
| <b>II</b>     | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>  | -                    | 114,737,423.00        |
| <b>1311</b>   | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | -                    | 114,737,423.00        |
| 131104        | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан<br>төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан<br>хөрөнгө | -                    | 114,737,423.00        |

## 3. Аудитын тайлан

### **3.1. Ерөнхий зүйл**

Баяннуур сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Засаг даргын тамгын газрын дарга Д.Жигмэд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, биет бус хөрөнгийг зөв бүртгэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 04-нөөс 2021 оны 02 дугаар сарын 08-ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Содном, аудитор Д.Даариймаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Баяннуур сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Булган аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн А/424 тоот захирамжаар Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллажээ.

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Могод сумын Засаг даргын тамгын газар нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “11642.2” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 241631.0 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 4832.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баяннуур сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 108627.5 мянган төгрөгөөр буюу 10.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл   | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт         |
|---|------------------|-----------------|------------------|
| Б   | 1                | 2               | 3=2-1            |
| Мөнгөн хөрөнгө                                    | 0                | 0               | 0                |
| Авлага  | 282.2            | 4333.1          | 4050.9           |
| Урьдчилгаа  | 0                | 120.0           | 120.0            |
| Бараа материал                                    | 49794.2          | 11076.7         | -38717.5         |
| Үндсэн хөрөнгө                                    | 990186.7         | 916105.8        | -74080.8         |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>1040263.2</b> | <b>931635.7</b> | <b>-108627.5</b> |
| Өр төлбөр   | 565.5            | 0               | -565.5           |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/               | 1039697.6        | 931635.7        | -108061.9        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>1040263.1</b> | <b>931635.7</b> | <b>-108061.9</b> |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэлгүй тайлагнажээ.

Авлага дансны үлдэгдэл 4333.1 мянган төгрөг болж 4050.9 мянган төгрөгөөр өссөн нь ХХОАТ-ын өглөгийг барагдуулаагүйгээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 11076.7 мянган төгрөг болж 49794.2 мянган төгрөгөөр буурсан нь шинэ хөдөө төсөлт 30150.7 мянган төгрөгийн чацарганы хашаа үнэ төлбөргүй шилжүүлснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 916105.8 мянган төгрөг болж 74080.8 мянган төгрөгөөр буурсан нь 85298.5 мянган төгрөгийн хөрөнгө акталснаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн мянган төгрөгийн 68216.4, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлээр 4174.5 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 34267.2 мянган төгрөг, акталсан 85298.5 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 565.5 мянган төгрөгөөр буурсан нь ХХОАТ-ын өглөгийг барагдуулснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 931635.7 мянган төгрөг болж 108061.9 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийн бууралтаас шалтгаалжээ.

Баяннуур сумын ЗДТГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 55847.8 мянган төгрөгөөр буюу 11.7 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилт, нэмэлт санхүүжилт, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 128459.9 мянган төгрөгөөр буюу 31.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн, тээвэр шатахууны, урсгал засварын, дотоод албан томилолтын, бараа үйлчилгээний, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардлууд байна. Энэ нь төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдлээс үүдэн цалингийн зардал өссөн, бусад үйл ажиллагааны зардлууд буурсан боловч нэмэлт санхүүжилт их байсантай холбогдуулан бараа үйлчилгээний зардал 101567.0 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 256700.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 256700.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 45381.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 302081.2 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 302081.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 301681.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 400.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 282878.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 694.5 мянган төгрөг, нийт 283573.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 280800.8 мянган төгрөгийг зарцуулж 2772.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 280800.8 мянган төгрөг буюу 99 хувьтай байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардал арга хэмжээ 539.7, баг хорооны үйл ажиллагааны зардал арга хэмжээ 1667.8, ажил олгогчоос олгох тэтгэмж арга хэмжээ 255.0, орон нутгийн нөөц хөрөнгө арга хэмжээ 309.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Баяннуур сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ХХААГ-аас оготно устгалын зардалд 21600.0, Мал эмнэлгийн газраас малын эмчийн өрөөний засварт 370.5, Статистикийн хэлтсээс ХАОСТ-ын зардалд 2775.4, БХС-гаас хогны тендер ариун цэврийн байгууламжийн санхүүжилт 88591.5, Гамшгаас хамгаалах сангаас постны

материалын санхүүжилт 1000.0 нийт 114737.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж зориулалтын дагуу зарцуулж 0.2 мянган төгрөг төвлөрүүлжээ.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 138 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 11 мэдээлэл байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4833.7 мянган төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт        | Өмнөх оны илрүүлэлт |        | Биелэлт |        | Зөрүү |     |      |
|-----------------|---------------------|--------|---------|--------|-------|-----|------|
|                 | Тоо                 | Дүн    | Тоо     | Дүн    | Тоо   | Дүн | Хувь |
| Акт             |                     |        |         |        |       |     |      |
| Албан шаардлага |                     |        |         |        |       |     |      |
| Зөвлөмж         | 4                   | 4833.7 | 4       | 4833.7 |       |     |      |
| Нийт дүн        | 4                   | 4833.7 | 4       | 4833.7 |       |     |      |

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 41814.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 35438.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 307.7 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 6068.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Үнэ төлбөргүй шилжүүлсэн 31264.2 мянган төгрөгийн бараа материалыг бараа үйлчилгээний зардалд бүртгэснийг үнэ төлбөргүй гарсан зардалд бүртгэж залруулсан.
2. Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 4174.5 мянган төгрөгийг өмчийн өөрчлөлтийн тайланд тусгасныг хөрөнгийн дахин үнэлгээний бичилтийн өөрчлөлтөөр залруулсан.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 307.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 307.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Хавсран ажилласны нэмэгдлийг илүү тооцож олгосон нь Засгийн газрын 2019 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2.2. “Энэ журмын 2.1-д заасан түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно.”, 2.4. “Төрийн албаны тухай хуулийн 3.1.4-т тодорхойлсон сул орон тооны албан үүргийг түр орлон гүйцэтгэх тохиолдолд тухайн албан тушаалын үндсэн цалингийн зөрүүг түр орлон гүйцэтгэсэн хугацаагаар тооцож олгоно. Албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн үндсэн цалин, сул орон тооны албан тушаалын үндсэн цалинтай адил буюу түүнээс бага байх тохиолдолд энэ журмын 2.2-т заасныг баримтална.” гэсэн заалтуудыг зөрчсөн, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Илүү олгосон 243.4 мянган төгрөгийн хавсран ажилласны нэмэгдэлд төлбөрийн акт тогтоох.

2. Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсан шатахууныг замын хуудасгүй зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.” заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Анхан шатны баримтгүй зарцуулсан шатахууны 64.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоох.

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 6068.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Даргаагийн аудитаар Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг анхааралдаа авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **1. Засаг даргын нөөц хөрөнгийн данстай холбоотой асуудал**

##### **1.1. Илрүүлэлт:**

Засаг даргын нөөц хөрөнгө болон нэмэлт санхүүжилтийн данснаас худалдан авсан шатахуун, бараа материалыг тусад нь бараа материалын тайлан гаргасан боловч нярвын тайлан, санхүүгийн тайланд бүртгээгүй.

##### **1.2. Эрсдэл:**

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

##### **1.3. Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх заалтыг мөрдөж ажиллах

**1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг хүлээн зөвшөөрсөн.

**2. Шилэн данстай холбоотой асуудал**

**2.1. Илрүүлэлт:**

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 138 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 11 мэдээлэл байна.

**2.2. Эрсдэл:**

Шилэн дансны тухай хууль хэрэгжихгүй байх.

**2.3. Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны мэдээллийг тухай бүр хугацаанд нь оруулах.

**2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Д.ДААРИЙМАА



## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

|                              |                            |   |                      |
|------------------------------|----------------------------|---|----------------------|
| Огноо:                       | Аудитын нэр:               | <b>Баяннуур сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b> | Аудитын код:         |
| 2020                         |                            |   | БУА-2021/149/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | <b>Баяннуур сумын ЗДТГ</b> |   | Мянган төгрөгөөр     |

| №          | Алдаа, зөрчлийн товч утга   | Мөнгөн дүн    | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл  | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны |                           |
|------------|---|---------------|--|---|---------------------------|
|            |   |               | Нэр  | Албан тушаал                                      | Овог нэр                  |
|            | 1   | 2             | 3  | 4   | 5                         |
| 1          | Хавсран ажилласны нэмэгдлийг илүү тооцож олгосон  | 243.4         | Илүү олгосон нэмэгдэлд төлбөрийн акт тогтоох   | Тамгын газрын дарга, нягтлан бодогч               | Д.Жигмэд, М.Булган-эрдэнэ |
| 2          | Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсан шатахууныг замын хуудасгүй зарцуулсан байна.   | 64.4          | Анхан шатны баримтгүй зарцуулсан шатахуунд төлбөрийн акт тогтоох                           | Тамгын газрын дарга, нягтлан бодогч               | Д.Жигмэд, М.Булган-эрдэнэ |
| 3          | Засаг даргын нөөц хөрөнгө болон нэмэлт санхүүжилтийн данснаас худалдан авсан шатахуун, бараа материалыг тусгд нь бараа материалын тайлан гаргасан боловч нярвын тайлан, санхүүгийн тайланд бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх заалтыг зөрчсөн байна. | 6068.2        | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх заалтыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөх.       | Тамгын газрын дарга, нягтлан бодогч               | Д.Жигмэд, М.Булган-эрдэнэ |
| 4          | Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 138 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 11 мэдээлэл байна.  | 0.0           | Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь оруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөх. | Тамгын газрын дарга, нягтлан бодогч               | Д.Жигмэд, М.Булган-эрдэнэ |
| <b>ДҮН</b> |   | <b>6375.9</b> |  |   |                           |